



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 1/298

Булган

Нэмэлт ажил гүйцэтгэх тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /а/, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн ам, бэлчээрийн усан хангамжид зориулж, шинээр худаг гаргах ажлын 2 дугаар багцад шалгарсан “Таширын хүрээ” ХХК-д Булган сумын 1 дүгээр баг “Байшинт”-д нэг худаг нэмж гаргах ажлыг гүйцэтгэх эрх олгосугай.
2. Таширын хүрээ ХХК-тай нэмэлт ажлыг 9370000 /есөн сая гурван зуун далан мянга/ төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ч.Амгалан/-д даалгасугай.
3. Нэмэлт ажлыг гэрээний дагуу хугацаанд нь, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Таширын хүрээ” ХХК /Д.Хэрлэн/-д үүрэг болгосугай.
4. Нэмэлт ажлыг батлагдсан эх үүсвэрээс нь хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Наранжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ